



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

www.bbsb.mn

**2014 оны
үйл ажиллагааны
үндсэн чиглэл**



АГУУЛГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Сургалт хариуцсан хороо
Стратеги бодлого хариуцсан хороо
Маркетинг хариуцсан хороо
Гишүүнчлэл хариуцсан хороо
Гадаад харилцаа хариуцсан хороо

САНХҮҮЖИЛТИЙН ТӨСӨВ

2014 оны төсөв

Сургалт хариуцсан хороо

Зорилго: ББСБ-ын салбарын боловсон хүчнийг чадваржуулах. Сургалтын стандарт хөтөлбөртэй болох

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- ✚ Холбооны сертификаттай сургалтыг бий болгох
- ✚ Тогтмол болон хэрэгцээт сургалтуудыг зохион байгуулах
- ✚ Зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх
- ✚ Гадаад, дотоод сургалтанд ББСБ-уудыг түлхүү хамруулах, мэдээллээр хангах

Зорилт 1: Холбооны сертификаттай сургалтыг бий болгох

ББСБ-ын шинэ ажилчид болон шинээр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй ББСБ-ууд, тэдгээрт ажиллаж буй нягтлан бодогч, зээлийн эдийн засагч, дотоод аудитор, теллерүүдэд зориулсан сургалтын стандарт бүхий хөтөлбөр боловсруулж, сертификаттай сургалтыг улирал бүр тогтмол зохион байгуулах. Цаашдаа шинээр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй ББСБ-уудын ажилтануудыг сертификатжуулсан сургалтанд хамрагдсан байх шалгуур оруулах.

Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах хамгийн оновчтой арга бол төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх явдал юм. Иймд Банк бус санхүүгийн салбарын ажилтануудыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу СЗХ-ноос сургалтын төсвийн дэмжлэг авч, сургалт зохион байгуулах эрх, үүргийг Холбоонд бүрэн шилжүүлэн авах.

Зорилт 2: Тогтмол болон хэрэгцээт сургалтуудыг зохион байгуулах

Сургалтын хэрэгцээ болон компанийн сайн засаглал, удирдлага, стратеги, эрсдэлийн удирдлага, макро эдийн засгийн бодлого, хэтийн төлөв, өмгөөлөл, гэрээний эрх зүйн байдал, барьцаалбарын талаар практик сургалтуудыг өргөн хүрээнд зохион байгуулах. ББСБ-ууд хооронд туршлага солилцох аяныг зохион байгуулах.

Зорилт 3: Зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх

Шинээр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй ББСБ-уудад зөвлөгөө өгөх, шаардлагатай дүрэм журмын талаар мэдээлэл өгөх үйлчилгээг нэвтрүүлэх. Мөн ББСБ-уудад нэн шаардлагатай гэрээ, дүрэм журам, хуулиудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж мэдээллээр хангах. /зээлийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн менежмент, хууль эрх зүй, маркетингийн удирдалага, менежмент/

Зорилт 4: Гадаад, дотоод сургалтанд ББСБ-уудыг түлхүү хамруулах, мэдээллээр хангах

Гадаад харилцааг өргөжүүлэх, ББСБ-н ажилтануудын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодод болох сургалт, семинарт ББСБ-уудыг хамруулах, сургалт семинар, уулзалтуудын мэдээллийг гишүүн ББСБ-ууддаа цаг алдалгүй тогтмол мэдээлэх. Гадаад сургалтыг эх орондоо зохион байгуулах, БСА, МҮХАҮТ, ММНБИ зэрэг мэргэжлийн байгууллагуудтай байнгын холбоотой ажиллаж, сургалт, семинарт ББСБ-уудыг түлхүү хамруулах, үнэ тарифийн хөнгөлөлт эдлүүлэх.

Стратеги бодлого хариуцсан хороо

Зорилго: Монгол Улсын санхүүгийн зах зээлд эзлэж буй ББСБ-ын салбарын байр суурийг улам бэхжүүлэх, хөгжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- ✚ Хууль эрхзүйн орчныг сайжруулах
- ✚ ББСБ-ын активын өсөлтийг сайжруулах
- ✚ Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх
- ✚ Мэдээлэл технологийн ололтыг нэвтрүүлэх
- ✚ Төрийн болон ТББ-ын хамтын ажиллагаа

Зорилт 1: Хууль эрх зүйн орчныг сайжруулах

ББСБ-ын салбарын зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт, зохицуулалтыг зохистой түвшинд байлгах бизнесийн хөгжлийг хурдасгах зорилгоор "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулах.

Хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд саналаа оруулах.

ППШГ ажиллагааг хөнгөвчлөх талаар СЗХ, МБХ-той хамтран ажиллах / Жишээ нь Гүйцэтгэлийн ажиллагааг тодорхой хугацаатай болгож хуулинд оруулж өгөх. Хариуцагч шийдвэр гүйцэтгэгч 2 харилцан тохиролцож хугацааг ихээхэн удаашруулах боломжтой байдал байсаар байна./

Шүүхийн ажиллагааг санхүүгийн бизнесийн онцлогт уялдуулах, хугацааг богиносгох /эвлэрүүлэн зуучлах/, Барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах аргыг хялбаршуулах зэрэг асуудлаар санхүүгийн зах зээлийн оролцогчид ялангуяа МБХ, СЗХ, МБ-тай хамтран ажиллагаа зохион байгуулах /Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой иргэний хэргийг бусад иргэний хэрэг шиг хугацаанд шүүхийн ажиллагааг явуулдгийг болиулж өөрөөр авч үздэг болгох./

Иргэд зээлийн үйл ажиллагааг аж ахуйн хэлбэрээр явуулдаг байдлыг зогсоох, Иргэний хуулийн тайлбар гаргуулан холбогдох газруудад нэг мөр ойлголтыг өгөх.

Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг бий болгох талаар идэвхитэй ажиллана.

СЗХ-ны дүрэм журам, тогтоол шийдвэр гаргахад Холбооны зүгээс санал, байр сууриа оруулж хэрэгжүүлэхэд ойлгомжтой, тодорхой болгоход хамран ажиллах. СЗХ-ноос шаарддаг бичиг цаасны асуудлыг хөнгөвчлөх, багаслах ажлын хүрээнд хурал уулзалтуудыг зохион байгуулах. /Төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг улам сайжруулан өмнөх ололтоо бататган, сайн ажиллах/

Монгол банкны Мөнгөний бодлогод ББСБ-уудын үйл ажиллагааг чиглүүлэн хамтарч ажиллах.

Зорилт 2: ББСБ-ын активын өсөлтийг сайжруулах

Зохистой харьцааны үзүүлэлтүүдийг сайжруулах, санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх.

Дотоодын төсөл хөтөлбөрт ББСБ-уудыг хамруулах, зээл авах боломжийг нэмэгдүүлэх. ЖДҮХС, БСХС, Нийслэлийн жижиг дунд бизнесийг дэмжих урт хугацаатай, бага хүүтэй эх үүсвэрийг ББСБ-уудаар дамжуулан зээлдүүлэх, Холбооноос шалгуур үзүүлэлтийг гаргаж хяналт тавьж ажиллах.

Гадаадын төсөл хөтөлбөрт ББСБ-уудыг хамруулах, зээл авах боломжийг эрэлхийлэх, мэдээллээр хангах, дэмжих.

Стратеги бодлого хариуцсан хороо

Зорилт 3: Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх

Хадгаламж, Санхүүгийн түрээс, IPO /хувьцааг нийтэд арилжаалах/, Итгэлцэл, Өрийн бичиг, Хөрөнгө итгэмжлэх, Үнэт цаас, Даатгал, Цахим мөнгөний үйлчилгээнд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг гаргах боломжийг судлах, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Компаний засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ББСБ-ын компаний засаглалыг хөгжүүлэх талаар судалгаа хийж, бодлого боловсруулах.

Зорилт 4. Мэдээлэл, технологийн дэвшилтэд ололтыг нэвтрүүлэх

Зээлийн мэдээллийн санд 100 хувь хамрагдах, ЗМС-н эрхийн асуудлыг оруулж өгөх шаардлагатай. /ЗМСанд муу харилцаж байгаа нь нэгд программ хангамжгүй, төсөв зардал гаргадаггүй, нээлттэй ил тод байхыг хүсдэггүй, программаа хэрэглэж чаддаггүй, мэддэггүй зэргээс шалтгаалдаг байна. Мөн ЗМСанд нэвтрэх эрхийн хувьд 1 ББСБ-д зөвхөн нэг эрх өгч байгаагаас ажилд хүндрэл учруулж байна.

ББСБ-ын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн шинэ дэвшилтэд ололтыг нэвтрүүлэх, гаднаас бичил санхүүгийн байгууллагуудын судалгаа хийж, мэдээлэх.

Зорилт 5. Төрийн ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо

Харилцан ойлголцлын санамж бичгийг 2014 онд шинэчлэн байгуулж, санамж бичгийн хүрээнд сургалт, ажлын байрны стандарт, тайлагналын чиг үүргийг холбоонд авах болон ББСБ-ын талаар эерэг, зөв ойлголтыг олон нийтэд хүргэх, мэдээлэл, маркетингийн чиглэлд хамран ажиллах.

Шинээр ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч буй ААН-н ажилтануудад Холбооны сургалтанд хамрагдсан байх шалгуурыг оруулах. Цаашид шинээр тусгай зөвшөөрөл олгох ажиллагааны шалгуурыг нэмэгдүүлэх, босгыг өндөрсгөх, холбооны санал оруулж, хяналт тавьдаг болгох.

СЗХ-ны орон тооны бус зөвлөлд байр сууриа илэрхийлэн, идэвхитэй оролцох.

Холбооны гишүүн ББСБ болон СЗХ-ны хамтын ажиллагааг сайжруулах, гишүүдэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх зорилгоор гишүүн ББСБ-ууд болон СЗХ-ны нэгдсэн ЗАНГИАГҮЙ УУЛЗАЛТЫГ улиралд бүр тогтмол зохион байгуулах.

МҮХАУТанхим: Танхимын дэргэдэх Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөлөөр дамжуулан аливаа сургалт семинарт ББСБ-уудыг хамруулах, нягт холбоотой хамтран ажиллах. Жил бүр уламжлал болгон шалгаруулдаг TOP 10 ББСБ-уудын шалгаруулалтад холбооноос байр сууриа илэрхийлэх. Танхимаар дамжуулан төрийн дээд байгууллагуудтай хамтран ажиллах, нийтлэг ашиг сонирхолоо хамгаалан хөгжүүлэх.

Бусад мэргэжлийн холбоод: Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн мэргэжлийн холбоодтой хамтран санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, бизнесийн эрүүл орчныг бүрдүүлэхэд хамтын ажиллагаагаа өргөтгөх, бэхжүүлэх зорилгоор “Хамтын ажиллагааны санамж бичиг”-н хүрээнд хамтран ажиллах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх. /МБХ, МББСБХолбоо, МҮЦАЭХ, Монголын даатгалын холбоо, Монголын лизингийн холбоо, ХЗХ-ын холбоо/

Маркетинг хариуцсан хороо

Зорилго: ББСБ болон Холбооны үйл ажиллагааны талаар нийгэмд эерэг ойлголтыг бий болгох.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- ✚ ББСБ-уудын болон холбооны үйл ажиллагааг сурталчилах
- ✚ Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, ББСБ-ыг сурталчилах
- ✚ ББСБ-уудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх
- ✚ Судалгаа, шинжилгээ

Зорилт 1. ББСБ-уудын болон холбооны үйл ажиллагааг сурталчилах

E-NEWSLETTER буюу банк бус санхүүгийн салбарын цахим сэтгүүлийг улирал бүр эрхлэн гаргаж танхимтай байнгын холбоотой 19 аймгийн 21 салбарын бүх гишүүд болон танхимын албан ёсны мэдээллийн сайтуудаар дамжуулан гишүүн ББСБ-ууд болон холбооны үйл ажиллагааг тогтмол сурталчилах, мэдээлэх.

ББСБ-уудын үйл ажиллагаа болон холбооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах, таниулах зорилгоор МҮОНТВ-н өглөө хөтөлбөр, гэрэлтэй цонх, SBN ТВ-н Их цэвэрлэгээ, Bloomberg зэрэг нэвтрүүлгүүдэд оролцох. Мөн өдөр тутмын сонин, сэтгүүл, интернэт сайтуудтай хамтран ажиллах.

Мэргэжлийн сэтгүүл сонинд ББСБ-н мэдээллийг сурталчилан таниулах ажлыг тогтмол зохион байгуулах. МҮХАҮТанхимаас эрхлэн гаргадаг бүх төрлийн сэтгүүл сонинтой тогтмол хамтран ажиллаж Бизнес ба хөгжил сэтгүүл болон Бизнес таймс сонинд мэдээлэл нийтлүүлж байх.

Гишүүн ББСБ-уудын нийгмийн хариуцлагын чиглэлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан алдаршуулах. /Холбооны вэб хуудас, Өдөр тутмын сонин, мэдээллийн сайтууд, Бизнес таймс, Бизнес мэдээ сонин, MDF-н сонин сэтгүүл гэх мэт/

Холбооны вэб сайт, Facebook page-г тогтмол ажиллуулж ББСБ-уудад хэрэгцээтэй хууль, дүрэм, журам, санхүүгийн салбарын мэдээлэл, бүх гишүүдийн хурал, УЗ хурал, уулзалт, цуглааны мэдээ, тайлан дүгнэлтийг бүх гишүүдэд тухай бүр мэдээлж, вэб сайтанд байршуулж байх.

Нийт ББСБ-ууд, хамтран ажиллагч, дэмжигч байгууллагууддаа тэмдэглэлт ойн арга хэмжээ, баярын мэндчилгээг тогтмол хүргэж байх, нийтэд сурталчилах.

Зорилт 2. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, ББСБ-ыг сурталчилах

Холбоо, ББСБ-ууд болон СЗХ-той хамтран иргэдийн санхүүгийн боловсролын нэмэгдүүлэх ажлуудыг шат дараалалтайгаар хийж хэрэгжүүлэх. Төсөл боловсруулж, санхүүжилтыг бүрдүүлэх. Үүнд:

- ББСБ гэж юу вэ? цуврал баримтат кино, богино хэмжээний мэдлэг олгох цуврал рекламыг хийх. ТВ-үүд болон СЗХороотой хамтран ажиллаж ТВ-н санхүүгийн боловсрол олгох цуврал нэвтрүүлэг хийх.

Бусад мэргэжлийн холбоодтой хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх ажлуудыг шат дараалалтайгаар хийж хэрэгжүүлэх.

- Санхүүгийн салбар, онцлогууд зэргийг товч бөгөөд дэлгэрэнгүй тусгасан богино хэмжээний цуврал нэвтрүүлэг, баримтат кино, ТВ-н ярилцлагууд бэлтгэх.

Маркетинг хариуцсан хороо

Зорилт 3. Нийгэмд чиглэсэн арга хэмжээ

Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа, хандив тусламж, хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулах, ББСБ-ууд болон холбооны үйл хэргийг нийтэд сурталчилах, таниулах. /мод тарих, хог түүх, цас цэвэрлэгээ, хандивын үйл ажиллагаа гэх мэт/

Оюуны эрэлд эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотын их дээд сургуулиуд болон ББСБ-уудын ажилтануудын дунд 3 дахь жилдээ зохион байгуулах. Эрдэм шинжилгээний хурлын сүүлийн шатанд шалгарсан материалуудаар эмхэтгэл гарган архивлах. Хандивлагч, ивээн тэтгэгчдийг татан оролцуулах.

Ногоон төгөл төслийн ажлыг эхлүүлэх. Уг төсөл нь гишүүн ББСБ-уудын хамтын ажиллагааг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, нийгэмд эерэг ойлголтыг бий болгох зорилготой.

Үндэсний өгөх өдөр буюу 2013.11.01-ны өдрийг нийт ББСБ-уудын дэмжлэгтэйгээр тэмдэглэн өнгөрүүлэх.

Ажилтануудын ажлын байр, ажиллах орчин нөхцлийг сайжруулах, ажлын хувцас, формжуулах, ажлын байрны стандартыг бий болгох, Ажлын байрны стандартыг нэвтрүүлэн хэвшүүлэх.

ББСБ-уудад Үйлчилгээний стандарт, ажлын байрны стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Зөвлөмж гаргах. Үйлчилгээний болон ажлын байрны стандартыг үлгэр жишээ нэвтрүүлж буй ББСБ-ыг тодруулан, Батламж гардуулах ажиллагаа зохион байгуулах.

ББСБ-уудын талаар нийгэмд эерэг ойлголт бий болгох ажлын хүрээнд:

- ✚ Нийгмийн хариуцлагын ISO 26000 стандартыг нэвтрүүлэх
- ✚ Авилга авахгүй, өгөхгүй аянуудыг өрнүүлэх

Зорилт 4. Судалгаа, шинжилгээ

- Салбарын болон холбооны гишүүдийн тайлан тэнцэлийн нэгтгэлд дүн шинжилгээ, судалгаа хийж улирал бүр гишүүдэд мэдээлж байх.
- Хагас жил тутам зах зээлийн бодит судалгаа хийж, гишүүдэд мэдээлж байх. /ББСБ-ын нөхцөл байдлын судалгаа, зээлийн хүү бүрдэлтийн судалгаа, харилцагчийн зан төлөвийн судалгаа, харилцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, ОУ-ын ББСБ-ын чиг хандлагын судалгаа/

Гишүүнчлэл хариуцсан хороо

Зорилго: Холбооны гишүүний давуу талыг нэмэгдүүлэх, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн арга хэмжээ, ажиллагаа явуулах, гишүүнчлэлээ нэмэгдүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- ✚ Гишүүнчлэлийн нэмэгдүүлэх, гишүүдийн давуу талыг нэмэгдүүлэх
- ✚ Салбарын тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулах
- ✚ Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээ, шагналд тодорхойлох

Зорилт 1. Гишүүнчлэл

Холбооны үйл ажиллагааны танилцуулга, гишүүн болсны давуу талыг гишүүн болон гишүүн бус ББСБ-уудад хүргэх, сурталчилах, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх ажлыг шинэ түвшинд гаргах. Шинэ гишүүдэд зориулсан уулзалт, сургалтыг улирал тутам зохион байгуулах. Холбооны гишүүнчлэлийг Банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт ББСБ-уудын 50%-д хүргэх.

Холбооны гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудыг эгнээндээ нэгтгэх. Голлох бүсүүдэд төлөөлөгчтэй болох.

Шинэ гишүүдийн уулзалтыг тогтмол зохион байгуулах. Хагас жил бүр шинэ ББСБ-уудад батламж гардуулах арга хэмжээ зохион байгуулж, гишүүдийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах.

Холбооны гишүүний давуу талыг нэмэгдүүлэх, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмын заавар, хэрэгжилтийн талаар зөвлөгөө мэдээллээр хангах Зээлийн гэрээний загварууд, НББ, хүний нөөцийн чиглэлээр анхан шатны маягтын талаар нэгдсэн мэдээллээр хангаж байх

Зорилт 2. Тэмцээн, уралдаан

Гишүүн ББСБ-ууд, тэдгээрийн ажилтан албан хаагчдын хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Банк бус санхүүгийн салбарын спортын төрлийн шилдэгийг шалгаруулах Шилжин явах цомын төлөөх трээний теннис, волейбол, сагсан бөмбөгийн тэмцээнүүдийг 3 төрөлд өргөн хүрээнд зохион байгуулах. Тэмцээний зохион байгуулалтанд 2013 оны Шилжин явах цомын эзэн ББСБ-уудтай хамтран ажиллах.

ББСБ-уудын захирлууд, удирдах ажилтануудын дунд олон төрөлт спортын арга хэмжээг зохион байгуулах. /боулинг, гольф/

Монголбанк, Арилжааны банкууд, ББСБ-уудын хоорондох 2014 оны аварга шалгаруулах тэмцээнд Холбооны шигшээ багыг бэлтгэж оруулах.

Ажилтануудын бие бялдар, эрүүл ахуйн аянг уламжлал болгон зохион байгуулах. Эрүүл агаар, спорт зэрэг аялалуудыг зохион байгуулах.

Зорилт 3. Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээ, шагналд тодорхойлох

Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээг 7 дахь жилдээ зохион байгуулалттайгаар өргөн хүрээнд зохион байгуулах. Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээг бэлэг тэмдэгтэй болгох. /Алтан сарнай, Алтан шонхор/

Төрийн дээд одон, медаль, СЗХ, МҮХАҮТ-ын шагналд ББСБ-уудаа нэр дэвшүүлэн, шагнан урамшуулах.

Холбооны шагналын журмын дагуу Банк бус санхүүгийн салбарын тэргүүний ажилтан болон Банк бус санхүүгийн салбарын 2014 оны шилдэг байгууллага, ажилтануудыг шалгаруулан, шагнан урамшуулах. Банк бус санхүүгийн салбарын шилдэг ажилтануудыг бэлэг тэмдэг бүхий цомтой болох.

Гадаад харилцаа хариуцсан хороо

Зорилго: Гадаад харилцааг хөгжүүлж, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- ✚ Хүний нөөцийн чадавхийг сайжруулахад чиглэгдсэн сургалтын үйл ажиллагаа
- ✚ Санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэгдсэн гадаад харилцааны үйл ажиллагаа
- ✚ Байгууллагын хөгжилд чиглэгдсэн гадаад маркетингийн үйл ажиллагаа
- ✚ Судалгаа, хөгжилд чиглэгдсэн үйл ажиллагаа

Зорилт 1. Хүний нөөцийн чадвар, сургалтын хүрээнд

Гадны улс орнуудад явагдах богино болон дунд хугацааны сургалтуудыг судлах, гишүүн байгууллагуудыг сургалтанд хамруулах.

Зээлийн судлагааны технологийг сайжруулах, нэвтрүүлэх зорилгоор ОУ-ын санхүүгийн болон холбогдох байгууллагаас техникийн туслалцаа авах боломжийг судлах, хэрэгжүүлэх.

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай туршлага солилцох, дадлагажих зорилгоор солилцооны хөтөлбөр судлах, хэрэгжүүлэх.

Зорилт 2. Санхүүгийн эх үүсвэр, хамтын ажиллагааны хүрээнд

Гадны хөрөнгө оруулагчидыг судлах, бизнес харилцаа тогтоох, хамтран ажиллах.

Гадны хөрөнгө оруулагчидтай харилцаж хамтын ажиллагааг өргөжүүлэх, бичил санхүүгийн болон холбоотой чуулга уулзанд оролцох.

Гадаад харилцааны үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчидын мэдээлэл, шаардлагыг МББСБХ-нд /гишүүн байгууллагуудад/ танилцуулах.

Хөрөнгө оруулагчдын зүгээс хийгдэх "Зээлийн Судалгааны Ажил"-ыг зохион байгуулах /Due Diligence/. Гадаад харилцааны үйл ажиллагааг таниулан сурталчлах, энэ талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах.

Хөрөнгө оруулагчдын зүгээс хийгдэх "Зээлийн хяналтын ажил"-ыг зохион байгуулах /Monitoring/.

Зорилт 3. Байгууллагын хөгжил, гадаад маркетингийн хүрээнд

Олон улсын санхүүгийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсанд гишүүн байгууллагын талаарх мэдээллийг оруулах.

"Олон улсын Санхүүгийн болон үйл ажиллагааны үнэлгээ" хийлгэх зарчим, нөхцлийг судлах, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх /Financial and Operational Rating/.

"Олон улсын Нийгмийн Хариуцлагын Үнэлгээ" хийлгэх зарчим, нөхцлийг судлах, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх /Social Rating/.

Олон улсын үнэлгээ хийлгэх боломж, ач холбогдлыг МББСБХ-нд танилцуулах, гишүүн байгууллагуудын үнэлгээг хийлгэхийг уриалах.

Олон улсын болон Азийн бичил санхүүгийн холбоонд нэгдэх боломжийг судлах, гишүүн байгууллагуудыг элсүүлэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох /BWTP/.

Зорилт 4. Судалгаа, хөгжлийн хүрээнд

Гадны улс орнуудын санхүүгийн байгууллагуудын баримтлах зарчим, мөрдөгдөх хууль, журмыг судалж, нэвтрүүлэх.

Олон улсын байгууллага болон гадны орны засгийн газар, санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх боломжийг судлах, хэрэгжүүлэх.

Холбооны сайтыг англи хэл дээр болгож байнга мэдээллээ шинэчилж байх.

Mixmarket.mn дээр Холбооны мэдээллийг байнга шинэчилж байх.

Microfinance center буюу Бичил санхүүгийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах. Холбооны шугамаар гишүүн ББСБ-уудаа Олон улсын чуулга уулзалт, сургалт, семинарт хөнгөлөлттэй үнээр түлхүү оролцуулах, техникийн болон санхүүгийн дэмжлэг, мэдээлэл, арга зүйн туслалцаа авах, хөрөнгө оруулагч байгууллагуудтай холбоо, харилцаа тогтоох улмаар санхүүжилт босгох боломжуудыг олгохыг зорин ажиллах.

Дэлхийн бичил санхүүгийн төвийн 17 дахь уулзалтанд гишүүн ББСБ-уудыг өргөнөөр хамруулах, семинарт оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хамруулах.

Smartcampaign буюу Олон улсын харилцагчдын эрх ашгийг хамгаалах хөдөлгөөнийг дэмжин ажиллах. Энэ хөдөлгөөн нь 2013 оноос эхлэн Олон улсын (Financial rating) санхүүгийн үнэлгээний нэгэн адил, ялангуяа гаднаас хөрөнгө оруулалт, санхүүжилт татаж байгаа байгууллагууд заавал хэрэгжүүлэх шаардлагатай болж байгаа тул гишүүн ББСБ-уудаа хамруулах.

Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах: Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD), Олон улсын санхүүгийн корпораци (IFC), Азийн хөгжлийн банкны дэргэдэх байгууллагууд, USAID, GTZ, Milenium challenge, Дэлхийн банк, ОУ-ын валютын сан зэрэг ОУ-ын болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, төсөлд хамрагдах, хамтарч ажиллах боломжийг судлах.



САНХҮҮЖИЛТИЙН ТӨСӨВ

2014 оны орлого, зардлын төсөв

САНХҮҮЖИЛТИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Үйл ажиллагааны төсөв	
			Нэгжийн өртөг	2014 оны төсөв
Орлого				
1.1	Ерөнхийлөгч	1 ББСБ	2,000,000	2,000,000
1.2	Удирдах зөвлөл (8 ББСБ)	8 ББСБ	1,000,000	8,000,000
1.3	Энгийн гишүүн - элссэн байгаа (52)	52 ББСБ	600,000	31,200,000
1.4	Энгийн гишүүн - шинээр элсүүлэх (30)	30 ББСБ	600,000	18,000,000
1.5	Сургалтын үйл ажиллагаанаас орлого	улиралд 1 удаа	500,000	2,000,000
1.6	Хүүний орлого	жилд	5,000,000	5,000,000
Нийт орлого			9,700,000	66,200,000
Зардал				
1	Цалингийн зардал		9,665,000	28,280,000
1.1	Гүйцэтгэх захирлын цалинд	12 сард	1,500,000	18,000,000
1.2	БГА-бусдаар гүйцэтгүүлсэн ажил	жилд	3,000,000	3,300,000
1.3	Томилолтын зардал	жилд	5,000,000	5,000,000
1.4	НДШимтгэлд (байгууллага хариуцах 11%)	12 сард	165,000	1,980,000
2	Хороодын үйл ажиллагаанд		13,500,000	13,500,000
2.1	Гишүүнчлэлийн хороо	жилд	2,500,000	2,500,000
2.2	Маркетингийн хороо	жилд	2,500,000	2,500,000
2.3	Сургалтын хороо	жилд	2,500,000	2,500,000
2.4	Стратеги бодлогын хороо	жилд	2,500,000	2,500,000
2.5	Гадаад харилцааны хороо	жилд	2,000,000	2,000,000
2.6	Брэнд бүүк, боршур, тараах материал	жилд	1,500,000	1,500,000
3	Шуудан холбооны зардал		1,385,000	3,020,000
3.1	Вэб байршуулах, засвар үйлчилгээ	жилд	1,200,000	1,200,000
3.2	Утасны төлбөр	12 сард	100,000	1,200,000
3.3	Интернэт	12 сард	35,000	420,000
3.4	Хэвлэл захиалга	улиралд 1 удаа	50,000	200,000
4	Үйл ажиллагааны зардал		2,200,000	15,400,000
4.1	Бэлэг дурсгал (ББСБ-уудын ой,	жилд	1,000,000	1,000,000
4.2	Зочин төлөөлөгчийн зардал	12 сард	500,000	6,000,000
4.3	Тээврийн зардал	12 сард	100,000	1,200,000
4.4	Оффис зардал	12 сард	50,000	600,000
4.5	Цай кофений зардал	12 сард	100,000	1,200,000
4.6	Хэвлэл мэдээллийн зардал	12 сард	250,000	3,000,000
4.7	Бусад	12 сард	200,000	2,400,000
5	Тоног төхөөрөмж худалдан авах, сайжруулах		4,812,000	1,800,000
5.1	Өнгөт принтер	жилд	600,000	600,000
5.2	Нуруулдагч	жилд	200,000	200,000
5.3	Бусад / цом, /	жилд	1,000,000	1,000,000
6	Бүртгэлийн хураамж		1,506,000	1,506,000
6.1	Microfinance center /500EUR/	жилд	1,200,000	1,200,000
6.2	Mixmarket	жилд	306,000	306,000
7	Бичиг хэргийн зардал		1,070,000	2,640,000
7.1	Гишүүний батламж - 30 гишүүн	жилд	800,000	800,000
7.2	Албан бланк, дугтуй г.м	жилд	100,000	400,000
7.3	Принтерийн хор /2сард 1ш/	2 сард 1 удаа	100,000	600,000
7.4	Бичгийн цаас /1сард 3ш/	12 сард	20,000	240,000
7.5	Бичиг хэрэг	12 сард	50,000	600,000
Нийт зардал				66,146,000
Ашиг (алдагдал)				54,000